### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Үенч сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг **аккруэл** сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Сумын нэгтгэсэн санхүүгийн тайланд мөрдөх тусгайлан баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй бөгөөд Сангийн яамнаас гаргасан бодлого шийдвэрүүдийг хэрэгжүүлэн и-баланс цахим программ хангамж ашиглан холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцүүлэн, үйл ажиллагааны онцлогт тохируулан ашиглаж байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Үенч сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 5,498.9 сая төгрөгөөр буюу 40 хувиар буурсан байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт*

/сая төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлтүүд	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	
Мөнгөн хөрөнгө	223.2	99.1	124.1	0.4
Авлага	181.5	269.4	(87.9)	1.5
Урьдчилгаа	85.8	85.8	-	1.0
Бараа материал	133.2	31.5	101.7	0.2
Үндсэн хөрөнгө	8,020.6	2,659.6	5,361.0	0.3
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>8,644.3</b>	<b>3,145.4</b>	5,498.9	0.4
Богино хугацаат өр төлбөр	19.7	27.7	(8.0)	1.4
Цэвэр хөрөнгө, өмч	8,624.6	3,117.7	5,506.9	0.4
<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>8,644.3</b>	<b>3,145.4</b>	5,498.9	0.4

Эх сурвалж: Үенч сумын ТТЗ-ын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дээрх хүснэгтээс харахад, санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлттэй мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилгаа, үндсэн хөрөнгө цэвэр өмч хөрөнгийн данснууд байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт хөрөнгө 40 хувиар буурсан гол шалтгаан нь орон нутгийн ЭМТөв, ЕБСургууль, СӨБ, Соёлын байгууллагууд нь улсын төсвөөс санхүүжилт авч тайлан балансаа харьяаны салбарт нэгтгэдэг болсонтой холбоотой байна.

### 3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 223.2 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 99.1 сая төгрөг болж 124.1 сая төгрөгөөр буюу 44.4 хувиар буурсан нь тайлант онд Хоршоо хөгжүүлэх сангаас өмнөх оны мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг зээл олгосонтой холбоотойгоор буурсан байна.

### 3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 269.3 сая төгрөг болж, өмнөх оноос 87.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №02 Авлагын үлдэгдэл

/сая.төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	10.0	7.3	(2.7)
Төлбөртэй үйлчилгээний авлага	28.1		(28.1)
Байгууллагаас авах авлага	20.2	19.0	(1.2)
Хувь хүмүүсээс авах авлага	6.3	11.8	5.5
Зээлийн хүүгийн авлага	108.3	222.7	114.4
Дансны авлага /ОНӨААТҮГ/	8.5	8.5	-
<b>Дүн</b>	<b>181.4</b>	<b>269.3</b>	<b>87.9</b>

Эх сурвалж: Үенч сумын ТТЗ-ын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага өссөн гол шалтгаан Хоршоо хөгжүүлэх сангаас 130.0 сая төгрөгийн эргэн төлөгдөх нөхцөлтэй зээл олгосон, 19.0 сая төгрөгийн авлага нь ОНХС-аас хийгдсэн ажлууд бүрэн хийгдээгүйтэй холбоотой, тусгай шилжүүлгийн байгууллагатай холбоотой 48.3 сая

төгрөгийн авлагыг балансаас балансад шилжүүлсэн, Үенч Эрчим хүч ТӨҮГ-ын 8.5 сая төгрөгийн авлага барагдуулах боломжгүй байна.

### 3.4.3 Урьдчилгаа

Тайлант оны эхэн болон эцэст урьдчилгаа дансны үлдэгдэл 85.8 сая төгрөг байна.

*Хүснэгт 3. Урьдчилгаа дансны үлдэгдэл*

*/сая төгрөгөөр/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	84.0	84.0	-
Бараа бэлтгэх урьдчилгаа	1.8	1.8	-
<b>Дүн</b>	<b>85.8</b>	<b>85.8</b>	-

Урьдчилж гарсан авлага нь 2014 оноос хойш хэрэгжиж байгаа малжуулах төслийн 84.0 сая, Үенч Эрчим хүч ТӨҮГ-ын 1.8 сая төгрөгийн авлага байна.

### 3.4.4 Бараа материал

Бараа материалын дансны үлдэгдэл 31.4 сая төгрөг болж 101.8 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт 4. Бараа материал дансны үлдэгдэл*

*/сая төгрөгөөр/*

Тайлангийн үзүүлэлтүүд	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
<b>Түүхий эд материал</b>	<b>48.1</b>	-	<b>48.1</b>
Тусгай зориулалттай материал	26.3		26.3
Эм боох материал	21.8		21.8
<b>Хангамжийн материал</b>	<b>85.1</b>	<b>31.4</b>	<b>53.7</b>
Бичиг хэргийн материал	0.5		0.5
Аж ахуйн материал	0.7	0.7	-
Түлш шатах тослох материал	1.5		1.5
Хүнсний материал	11.2		11.2
Бусад хангамжийн материал	66.3	25.8	40.5
Мал амьтад	4.9	4.9	-
<b>Нөөцийн бараа</b>	-		-
<b>Нийт бараа материал</b>	<b>133.2</b>	<b>31.4</b>	<b>101.8</b>

Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 86.8, аймгийн Онцгой байдлын газраас 2.4 сая төгрөгийн ковидын оношлуур, ОНХС-ийн сангийн хөрөнгө, аймгийн ЗДТГ-аас олгосон санхүүжилтээр 11.8 сая төгрөгийн өвс тэжээлийн нөөц бүрдүүлж, 84.7 сая төгрөгийн материалыг зарцуулж, 118.1 сая төгрөгийн бараа материалыг улсын төсвийн байгууллагуудын балансаас балансад шилжүүлсэнтэй холбоотой өөрчлөлт орсон байна.

### 3.4.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 14,460.9 сая төгрөг байсан тайлант онд ойн хандив, ОНХС-ийн хөрөнгөөр 238.1 сая төгрөгийн хөрөнгөөр нэмэгдэж, 6,914.7 сая төгрөгийн хөрөнгийг балансаас балансад шилжүүлж оны эцэст 7,784.3 сая төгрөг болж 6,676.6 сая төгрөгөөр буурсан байна.

### 3.4.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 30.8 сая, эцсийн үлдэгдэл 27.7 сая төгрөг болж 3.1 сая төгрөгөөр буурсан байна. Өр төлбөрийн 55.2 хувь буюу 17.0 сая төгрөгийн өр төлбөр нь Үенч Эрчим хүч ТӨҮГазар нь 2011 оноос үйл ажиллагаа явуулаагүй барагдуулах боломжгүй, аймгийн ЗДТГ-ын 10.0 сая төгрөгийн өглөг нь, ХХОАТ-тай холбоотой 0.6 сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэл байна.

### 3.4.7 Цэвэр хөрөнгө, өмч

Засгийн газрын оролцоо дансны оны эхний үлдэгдэл 8,624.6 сая төгрөг байснаас оны эцэст 3,117,7 сая төгрөг болж 5,506.9 сая төгрөгөөр буурсан нь нягтлан бодох бүртгэлийн өөрчлөлтөөр улсын төсвийн байгууллагын хөрөнгийг шилжүүлсэнтэй холбоотой, ОНХС-ын тайланд 14.0 сая төгрөгөөр өмнөх оны хүлээлгэн өгөөгүй ажилтай холбоотой авлага, өмнөх үеийн үр дүн дансанд залруулга хийсэн.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Үенч сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны нэгтгэсэн төсвийг аймгийн ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 04 өдрийн 5/07 тоот тогтоолоор 1,213.0 сая төгрөгөөр анх баталж 2022 онд 1 удаа тодотгон нэмэлт өөрчлөлт оруулан, сумын ИТХ-аар 2022 оны 07 дугаар сарын 19-ны 10/02 тоот тогтоолоор нийт 1,119.9 сая төгрөгөөр тодотгон баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 1,858.1 сая төгрөгийн төсөв баталснаас орон нутгийн төсвөөс 1,223.3, ОНХС-аас 506.6 санхүүжих, үндсэн үйл ажиллагааны орлогоос 0.6, туслах үйл ажиллагааны орлогоос 96.4, өмнөх оны үлдэгдлээс 31.2 сая төгрөгөөр тус тус санхүүжүүлэхээр батлагджээ.

Хүснэгт 5. Нийт орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

Санхүүжилтийн эх үүсвэр	/сая төгрөгөөр/	
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>1729.9</b>	<b>1691.7</b>
Орон нутгийн төсвөөс	1223.3	1185.1
Орон нутгийн хөгжлийн сан	506.6	506.6
<b>Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас</b>	<b>128.2</b>	<b>139.6</b>
Үндсэн үйл ажиллагааны орлогоос	0.6	
Туслах үйл ажиллагааны орлогоос	96.4	15.7
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	31.2	123.9
<b>ЭХ ҮҮСВЭРИЙН НИЙТ ДҮН</b>	<b>1858.1</b>	<b>1831.3</b>

Эх сурвалж: Үенч сумын ТТЗ-ын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Гүйцэтгэлээр орон нутгийн төсөв, татварын болон татварын бус орлого 1,185.1, ОНХС-ийн санхүүжилт 506.6, туслах үйл ажиллагааны орлого буюу сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс 15.7, урьд оны үлдэгдлээс 123.9 сая төгрөг нийт 1,831.3 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,826.1 сая төгрөгийг зарцуулж 5.2 сая төгрөгийг орон нутгийн ерөнхий орлогод төвлөрүүлжээ.

Үндсэн үйл ажиллагааны орлогоос оруулах 0.6 сая төгрөгийн орлогыг бүрдүүлээгүй, туслах үйл ажиллагааны орлого буюу сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс 14.0, хүүгийн орлого 1.0, алданги 0.7 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, туслах үйл ажиллагааны орлогыг 80.7 сая төгрөгөөр тасарсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,826.1 сая төгрөг буюу 98.2 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 8.6 сая, бараа үйлчилгээний бусад зардал 1.2 сая төгрөг, байр ашиглахтай холбоотой зардал 7.7 сая, урсгал шилжүүлэг 9.5, хөрөнгийн зардалд 38.7 сая төгрөгөөр буюу батлагдсан төсвийг 65.7 сая төгрөгөөр хэмнэгдэж, Хоршоо хөгжүүлэх сангийн зээлд 33.7 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт 6. Сумын татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөгөөр/*

Орлогын ангилал	2022 оны		Зөрүү
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
Татварын нийт орлогын дүн	916.1	785.3	130.8
Нийт орлого ба тусламжийн дүн	904.5	772.0	132.5
Татварын орлого	904.5	772.0	132.5
Орлогын албан татвар	443.8	462.3	(18.5)
Хувь хүний орлогын албан татвар	443.8	462.3	(18.50)
Цалин, хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогын	406.2	446.6	(40.4)
Үйл ажиллагааны орлого	6.5	7.6	(1.1)
Шууд бус орлого	31.1	8.1	23.0
Хөрөнгийн албан татвар	118.9	98.1	20.8
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	1.5	3.3	(1.8)
Бууны албан татвар	2.4	2.2	0.2
Малын тоо толгойн албан татвар	70.0	57.4	12.6
Иргэдийн мөнгөн хадгаламжийн хүүгийн орлого	45.0	35.2	9.8
Бусад татвар, төлбөр, хураамж	341.8	211.6	130.2
Бусад нийтлэг төлбөр, хураамж	10.2	8.2	2.0
Улсын тэмдэгтийн хураамж	2.0	1.4	0.6
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны	3.2	5.2	(2.0)
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	5.0	1.6	3.4
Газрын төлбөр	23.5	93.7	(70.2)
Газрын төлбөр	23.5	93.7	(70.2)
Байгалийн нөөц ашигласны төлбөр	308.1	109.7	198.4
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	305.0	105.3	199.7
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	1.1	1.2	(0.1)
Ойн нөөцийн төлбөр		0.1	(0.1)
Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	2.0	3.2	(1.2)
Татварын бус орлого	11.6	13.3	(1.7)
Торгуулийн орлого	11.0	13.3	(2.3)
Төсөвт байгууллагын өөрийн орлого	0.6	-	0.6

*Эх сурвалж: Үенч сумын ТТЗ-ын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Татварын орлогыг 785.3 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн нийт орлогыг 130.8 сая төгрөгөөр буюу 14.3 хувиар тасарсан байна.

Орлого тасарсан гол шалтгаан нь цалин хөлс, шагнал урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого 40.4 сая төгрөг, үл хөдлөх хөрөнгийн татвар 1.8 сая төгрөг, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 2.0, газрын төлбөр 70.2, ус рашааны нөөц ашигласны төлбөр 0.1, байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр 1.2, торгуулийн орлого 2.3 сая төгрөгөөр тус тус орлого давуулан биелүүлж, ан амьтан нөөц ашигласны төлбөр 199.7, малын тоо толгойн албан татвар 12.6, хог хаягдлын хураамж 3.4, иргэдийн мөнгөн хадгаламжийн хүүгийн орлого 9.8 сая төгрөгөөр тус тус тасалжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн тайлангаар Хөшөөт хөгжлийн сангаас 257.2, байгаль орчны барьцаа 8.7, аймгийн ЗДТГ-аас 10.4, аймгийн ИТХ-аас 1.5, Статистикийн хэлтсээс 1.3, БОАЖГ-аас 2.9, БТСГ-аас 0.5, сумын түүхт ойн хандивт 92.2, бэлнээр 100.4, ЗГ-ын ундны усны хөнгөлөлт 9.0, бусад 1.0, өмнөх оны татан төвлөрүүлэлтээс 11.1, нийт 496.1 сая төгрөгийн орлого бүрдүүлснээс, айл өрхийн ундны усны төлбөрт 6.0, Мирай кенсэцү ХХК-д өмнөх оны төсөвт байгууллагын түлш халаалтын зардлын өр төлбөр 257.2, хөнгөлөлттэй үнээр хивэг худалдан авахад 10.0 сая, хагас жилийн мал тооллогын зардалд 1.3 сая, биеийн тамир арга хэмжээний шагналын зардалд 0.5, хог хаягдлын зардалд 2.9, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардалд 0.3, ИТХ-ын төлөөлөгчийг чадавхжуулах сургалт арга хэмжээнд 1.2, сумын түүхт ойн арга хэмжээний зардалд 192.6 сая төгрөг зарцуулж орон нутгийн төсөвт 13.1 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Үенч сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, санхүү нягтлан бодох бүртгэл, хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг ахлах аудитор Д.Нарантуул 2023 оны 03 дугаар сарын 22-ны өдрөөс 03 дугаар сарын 27-ний хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 03-ний өдрийн 1/49 албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,243.3 сая төгрөгөөс 2 хувиар буюу 44.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдал тооцох хувийг 70 хувиар буюу 31.4 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор ЗДТГ, ИТХ-ын төсвөөс албан хэрэгцээнд шаардлагатай эсэх нь тодорхой бус материал худалдан авсан, тэмцээний зардал гаргасан байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд сумын ТТЗахирагч, ЗДТГ, ИТХ-ын 2021 оны төсвийн төсөл, 2022 оны хагас жилийн санхүүгийн тайлан баланс, батлагдсан төсвийн мэдээллийг байршуулаагүй, 95 мэдээллийг хугацаа хоцроосон, мөн ЗДТГ, ИТХ, Орон нутгийн хөгжлийн сангийн цалингийн зардлаас бусад зардлын таван сая төгрөгөөс дээш орлого, зарлагын ажил гүйлгээг бүрэн мэдээлээгүйг аудитын явцад залрууллаа.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### 4.5 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх аудитаар өгөгдсөн 23.0 сая төгрөгийн 1 төлбөрийн актыг барагдуулан, 83.9 сая төгрөгийн 1 албан шаардлагыг хэрэгжүүлэн ажиллаж хэрэгжилт 42.1 хувьтай байна.

Хүснэгт 7. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	24.5	1	23.0	1	1.5	93.9
Албан шаардлага	4	259.2	1	83.9	3	175.3	32.4
Зөвлөмж	6	229.2			6	229.2	-
<b>Нийт дүн</b>	<b>12</b>	<b>512.9</b>	<b>2</b>	<b>106.9</b>	<b>10</b>	<b>406.0</b>	<b>42.1</b>

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Малжуулах төслийн зээлийн 84.0 сая төгрөгийн авлага, сумын түүхт ойн хандивын зарцуулалт, сумын ЗДТГ болон ИТХ-ын шатахууны зарцуулалт, ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа хөрөнгө оруулалтын биелэлтүүдийг дараагийн аудитаар анхаарч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 217.0 сая төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 215.8 сая төгрөгийн алдааг залруулан 1.2 сая төгрөгийн зөвлөмж өглөө. Үүнд:

- ЗДТГ, ИТХ, ОНХС, сумын 90 жилийн хандивын мөнгийг хувь хүний харилцах дансаар нийт 109.1 сая төгрөгийн орлогыг мөнгөн гүйлгээний тайланд дутуу бүртгэсэн,
- Үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийг 20.5 сая төгрөгөөр,
- Өглөг 10.0 сая төгрөгөөр дутуу тусгасан,
- ОНХС-ийн хөрөнгөөр худалдан авсан өвч, тэжээл, ковидын оношлуур 14.2 сая төгрөгийн орлогод аваагүй,
- Авлагыг 24.5 сая төгрөгөөр дутуу бүртгэсэн,
- УТХО, ОНХС болон сумын ойгоор үнэ төлбөргүй ирсэн 20.5 сая хөрөнгийг орлогод аваагүй, ИТХ-ын тайланд хөрөнгө 3.0 сая төгрөгөөр илүү бүртгэсэн,
- Тайлант үеийн үр дүнг 14.0 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасныг аудитын явцад залруулсан.

Аудитаар нийт 352.6 сая төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс, 16.2 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 76.8 сая төгрөгийн албан шаардлага, 259.6 сая төгрөгийн 6 зөвлөмж өглөө.

### 5.1 Төлбөрийн акт

#### 5.1.1 Сумын ЗДТГ-ын холбоотой төлбөрийн акт

- ✓ Аймгийн Санхүү дотоод аудитаар тавигдсан актыг төсвөөс төлсөн, томилолтоор ажилласныг нотлох анхан шатны баримтгүйгээр томилолтын мөнгө олгосон, төсвийг зориулалт бусаар зарцуулсан, албан хаагчдад цалингийн урьдчилгаа олгоод илүү суутган авсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5.төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах;" , Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" гэсэн заалтуудыг зөрчсөн, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### 5.1.2 Сумын ИТХ-ын холбоотой төлбөрийн акт

- ✓ ИТХ-ын төлөөлөгч нарт 12 дугаар сарын улирлын урамшууллын зардал 2.3 сая төгрөгийг илүү олгосон,
- ✓ Батлагдаагүй зардлыг төсвөөс санхүүжүүлсэн, томилолтоор ажилласан эсэхийг нотлох анхан шатны баримтгүй, томилолтын мөнгө олгосон нийт 2.0 сая төгрөгийн,

#### 5.1.3 Орон нутгийн сантай холбоотой төлбөрийн акт

- ✓ ОНХС-ийн журамд заагдаагүй арга хэмжээ буюу үзвэр үйлчилгээний тасалбар худалдан авахад 2.0 сая төгрөгийн зардлыг сангийн хөрөнгөөр төлсөн,

### 5.2 Албан шаардлага

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

**5.2.1** Ажлаас халагдсан ажилтанд төсвөөс цалин олгоод буруутай этгээдээс нэхэмжилж аваагүй, авлагад тусгаагүй 9.8 сая төгрөгийн зөрчил илэрлээ. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянаж ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах, Захиргааны ерөнхий хуулийн 103.1-д Иргэн хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага иргэний хуулийн 498.5-д заасны дагуу нэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ"

**5.2.2** ЗДТГ, ИТХ-ын тайлант онд худалдан авсан түлээ, нүүрс, шатахууны материалын тайлан гаргалт хангалтгүй, шатахууны жолоочийн тооцоо бодоогүй 29.3 сая төгрөгийг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах" 20 дугаар зүйлийн 20.2.6-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Сангийн сайдын 2017 оны 347 дүгээр тушаалын НХМаягт БМ-9-д "бараа материалын тайланг нярав, эд хариуцагч нь аж ахуйн нэгж байгууллагын бүртгэлийн бодлогын баримт бичигт заасан хугацаанд агуулахын бүртгэлд үндэслэн материалын нэр төрөл тус бүрийн тоо хэмжээгээр нэгтгэн гаргана. Бараа материалын тайланг нярав, эд хариуцагч нар дээр хөтлөгдөж буй агуулахын бүртгэлтэй тулган шалган хүлээж авна"

ОНХС-аас хийгдсэн их завсар, хөрөнгө оруулалтын ажлууд нь ТЭЗҮ-ийн тооцоогүй, захиалагчийн хяналтын зардал суутган тооцоогүй, сумын 90 жилийн ойн арга хэмжээний үйл ажиллагааг санхүүжүүлсэн, төрийн албан хаагчдыг чадавхжуулах ямар сургалтад хэчнээн хүн хамрагдсан эсэх нь тодорхой бус, ИТХ-ын төлөөлөгчдийг чадавхжуулахад нийт 37.8 сая төгрөгийн зардал гаргасан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 60 дугаар зүйлийн 60.3.4-д "нийтийн эрх ашигт нийцээгүй үйл ажиллагаа", 60.3.6-д "орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ", 60.3.3-д "үндэсний их баяр наадмаас бусад баяр, наадам, ойн арга хэмжээ, шашны зан үйлийн болон ёслолын зардал;" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

## **5.3 Зөвлөмж**

### **5.3.1 Зардалтай холбоотой асуудал**

Илрүүлэлт: Ой арга хэмжээний зарцуулалтын анхан шатны баримтын бүрдүүлэлт дутуу, 192.6 сая төгрөгийн бараа материалын тайлан гаргаагүй, батлагдсан орон тооноос илүү үйлчлэгч ажиллуулан 1.1 сая төгрөгийн цалин олгосон, ИТХ-ын үндсэн хөрөнгийн дансанд 200 ширхэг "Иргэдийн элч төлөөлөгч" нэртэй 6.0 сая төгрөгийн номыг 2021 онд данс бүртгэлд тусгасан бодитоор оршин байхгүй нийт 200.8 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-д "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална", 5.1.4-д "жинхэнэ хэрэгжилтийн", 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлэх, хөрөнгийг данс бүртгэлд тусгах, батлагдсан орон тоогоор ажиллах,

### **5.3.2 Анхан шатны баримттай холбоотой асуудал**

Илрүүлэлт: ЗГ-аас олгосон цэвэр усны төлбөрийн санхүүжилт олгохдоо хэчнээн айл өрхийн ундны усны төлбөр олгосныг нотлох анхан шатны баримтгүй, бүрэн бус баримтаар томилолтын зардалд 6.3 сая төгрөгийг зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай

хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ"

Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтаар баталгаажихгүй ажил гүйлгээг гаргахгүй байх

### **5.3.3 Төрийн хэмнэлтийн тухай хуультай холбоотой асуудал**

Илрүүлэлт: ЗДТГ, ИТХ-ын төсвөөс албан хэрэгцээнд шаардлагатай эсэх нь тодорхой бус материал худалдан авсан, тэмцээний зардалд 24.3 сая төгрөгийг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" , Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5.төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах;"

Өгсөн зөвлөмж: Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалтыг мөрдөн ажиллах

### **5.3.4 Хоршоо хөгжүүлэх сантай холбоотой асуудал**

Илрүүлэлт: Хоршоо хөгжүүлэх сангаас зээл олгохдоо барьцаалбар үүсгээгүй, байгуулсан гэрээнд хамтран зээлдэгчээр гарын үсэг зуруулж баталгаажуулаагүй нь Хошоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журмын 6.10.7-д "барьцаа хөрөнгийн үнэлгээний жагсаалт, барьцаалсан үнэ, барьцаалсан эд хөрөнгийн гэрчилгээний эх хувь болон барьцаа хөрөнгийн улсын бүртгэлд бүртгүүлж барьцаалбар үйлдсэн тухай баримтыг хавсаргана" гэсэн заалтын хэрэгжилт хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Олгосон зээлүүдэд барьцаалбар үүсгэн улсын бүртгэлд бүртгүүлэх

### **5.3.5 Зардал, үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал**

Илрүүлэлт: Мал тоо толгойн албан татварын орлогын эх үүсвэрийг холбогдох хуульд заасны дагуу зарцуулаагүй, багуудад тоног төхөөрөмж аппаратур хөгжим худалдан авсан, үнэ ханш, хүчин чадал тооцоо судалгаагүйгээр 25.0 сая төгрөгийг зарцуулсан нь Сангийн сайдын 2021 оын 86 дугаар тушаалаар "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 4.5-д "сум, дүүргийн ОНХС-д төвлөрөх Малын тоо толгойн албан татварын орлогын хөрөнгөөр дараах чиг үүргийн хүрээнд хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ", 4.5.1- 4.5.11 дэх заалтыг мөрдөөгүй,

Өгсөн зөвлөмж: ОНХС-ийн журамд заасны дагуу зарцуулж хэвших

### **5.3.6 Шилэн данстай холбоотой асуудал**

Илрүүлэлт: Төсвийн төвлөрүүлэн захирагч, ЗДТГ, ИТХ-ын 2021 оны төсвийн төсөл, 2022 оны хагас жилийн санхүүгийн тайлан баланс, батлагдсан төсвийн мэдээллийг байршуулаагүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3-д "дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор;" , 6.1.4-д "жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор;" ,

Өгсөн зөвлөмж: Хуульд заасан хугацаанд холбогдох мэдээллийг үнэн зөв мэдээлэх

### 5.3.7 Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: ЗДТГ-ын хөрөнгөөр 1.2 сая төгрөгөөр худалдан авсан үндсэн хөрөнгө орлогод авч бүртгээгүй орхигдуулсан нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 4.33-б-д төсөвт байгууллага өөрийн орлогоос үндсэн хөрөнгө бэлтгэх, худалдан авахад Дт-Үндсэн хөрөнгө, Кт-мөнгөн хөрөнгө" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж: ЗДТГ-ын 2023 оны эхний улиралд багтаан орлогод авч, бүртгэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 6 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс Залруулсан		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Мөнгөн гүйлгээний тайланд орлого зөрүүтэй тусгасан /ЗДТГ, ИТХ, ОНХС/	5	8.7	5	8.7	-	-	5	8.7		
Сумын 90 жилийн ойн хандивын орлогыг тусгаагүй орхигдуулсан	1	100.4	1	100.4			1	100.4		
Үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл зөрүүтэй тусгасан	1	20.5			1	20.5	1	20.5		
УТХО, ОНХС болон сумын ойгоор үнэ төлбөргүй ирсэн хөрөнгийг орлогод аваагүй, ИТХ-ын тайланд хөрөнгө илүү бүртгэсэн	3	23.5	2	20.5	1	3.0	3	23.5		
Аймгийн Онцгой комиссоос үнэ төлбөргүй хуваарилсан ковидын оношлуур, ОНХС-ийн хөрөнгөөр худалдан авсан хивэг тэжээлийг орлогод аваагүй,	3	14.2	3	14.2			3	14.2		
Аймгийн ЗДТГ-аас өвч тэжээлийн нөөц бэлтгэхээр олгосон санхүүжилтийг өглөгөөр тусгаагүй	1	10.0	1	10.0			1	10.0		
Малчдад худалдсан тэжээлийн үнийг авлагаар бүртгээгүй, ОНХС-ийн тайланд хэрэгжүүлээгүй арга хэмжээг зардлаар бүртгэсэн	1	10.5	1	10.5			1	10.5		
Багийн дарга нарын өрөөнд хийгдсэн тавилга орлогод аваагүй орхигдуулсан	1	1.2	1	1.2					1	1.2
ОНХС-ийн 2021 оны худаг гаргах ажлыг хүлээн аваагүй бүрэн хийгдээгүй тул авлагаар бүртгээгүй орхигдуулсан	1	14.0	1	14.0			1	14.0		

Тайлант үеийн үр дүн зөрүүтэй илэрхийлсэн	3	14.0			3	14.0	3	14.0		
Дүн	20	217.0	15	179.5	5	37.5	19	215.8	1	1.2

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Үүнээс							
	Нийт алдаа		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Ой арга хэмжээний зарцуулалтын анхан шатны баримтын бүрдүүлэлт дутуу, бараа материалын тайлан гаргаагүй, худалдан авсан үндсэн хөрөнгө орлогод аваагүй, батлагдсан орон тооноос илүү үйлчлэгч ажиллуулан цалин олгосон, ИТХ-ын үндсэн хөрөнгийн дансанд 200 ширхэг "Иргэдийн элч төлөөлөгч" нэртэй номыг 2021 онд данс бүртгэлд тусгасан бодитоор оршин байхгүй	1	200.9					1	200.9
ЗГ-аас олгосон цэвэр усны төлбөрийн санхүүжилт олгохдоо хэчнээн айл өрхийн ундны усны төлбөр олгосныг нотлох анхан шатны баримтгүй, бүрэн бус баримтаар томилолтын зардалд	1	6.3					1	6.3
Мал тоо толгойн албан татварын орлогын эх үүсвэрийг холбогдох хуульд заасны дагуу зарцуулаагүй, багуудад тоног төхөөрөмж аппаратур хөгжим худалдан авсан, үнэ ханш, хүчин чадал тооцоо судалгаагүйгээр зарцуулсан	1	25.0					1	25.0
Хоршоо хөгжүүлэх сангаас зээл олгохдоо барьцаалбар үүсгээгүй, байгуулсан гэрээнд хамтран зээлдэгчээр гарын үсэг зуруулж баталгаажуулаагүй	1	-					1	
Аймгийн Санхүү дотоод аудитаар тавигдсан актыг төсвөөс төлсөн, томилолтоор ажилласныг нотлох анхан шатны баримтгүйгээр томилолтын мөнгө олгосон, төсвийг зориулалт бусаар зарцуулсан, албан хаагчдад цалингийн урьдчилгаа олгоод илүү суутгасан	1	9.9	1	9.9				
ИТХ-ын төлөөлөгч нарт 12 дугаар сарын улирлын урамшууллын зардлыг илүү санхүүжүүлсэн, батлагдаагүй зардлыг төсвөөс санхүүжүүлсэн, томилолтоор ажилласан эсэхийг нотлох анхан шатны баримтгүй, томилолтын зардалд зарцуулсан	1	4.3	1	4.3				
ОНХС-ийн журамд заагдаагүй арга хэмжээг санхүүжүүлсэн	1	2.0	1	2.0				
Ажлаас халагдсан ажилтанд төсвөөс цалин олгоод буруутай этгээдээс нэхэмжилж аваагүй, авлагад тусгаагүй	1	9.7			1	9.7		
ЗДТГ, ИТХ-ын тайлант онд худалдан авсан түлээ, нүүрс, шатахууны материалын тайлан гаргалт хангалтгүй, шатахууны жолоочийн тооцоо бодоогүй	1	29.3			1	29.3		
ОНХС-аас хийгдсэн их завсар, хөрөнгө оруулалтын ажлууд нь ТЭЗҮ-ийн тооцоогүй, захиалагчийн хяналтын зардал суутган тооцоогүй, ойн арга хэмжээний үйл ажиллагааг санхүүжүүлсэн, төрийн албан хаагчдыг чадавхжуулах ямар сургалтад хэчнээн хүн хамрагдсан эсэх нь тодорхой бус, ИТХ-ын төлөөлөгчдийг чадавхжуулах зэрэг зардал гаргасан	1	37.8			1	37.8		
<b>Дүн</b>	<b>10</b>	<b>325.2</b>	<b>3</b>	<b>16.2</b>	<b>3</b>	<b>76.8</b>	<b>4</b>	<b>232.2</b>

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/сая төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс	
			Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>				
Төсвийн төвлөрүүлэн захирагч, ЗДТГ, ИТХ-ын 2021 оны төсвийн төсөл, 2022 оны хагас жилийн санхүүгийн тайлан баланс, батлагдсан төсвийн мэдээллийг байршуулаагүй	1	-	1	-
Дүн	1	-	1	
<b>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</b>				
ЗДТГ, ИТХ-ын төсвөөс албан хэрэгцээнд шаардлагатай эсэх нь тодорхой бус материал худалдан авсан, тэмцээний зардалд зарцуулсан	1	24.3	1	24.3
Дүн	1	24.3	1	24.3
Нийт дүн	2	24.3	2	24.3

**ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**



ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2023 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 51/A2160424

Ховд

ХОА-2022/13/НА/СТА-ТТЗ  
ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Үенч сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн тайланд аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Аймгийн Санхүү дотоод аудитын шалгалтаар тавигдсан 2468.8 мянган төгрөгийн төлбөрийн актыг төсвөөс төлсөн, томилолтоор ажилласныг нотлох анхан шатны баримтгүйгээр 2345.4 мянган төгрөгийн томилолтын мөнгө олгосон, төсвийг зориулалт бусаар 4928.0 мянган төгрөг нийт 9742.2 мянган төгрөг,
2. Албан хаагчдад цалингийн урьдчилгаа олгоод 150.0 мянган төгрөгийг илүү суутган авсан
3. ОНХС-ийн журамд заагдаагүй арга хэмжээ буюу үзвэр үйлчилгээний тасалбар худалдан авахад 1990.0 мянган төгрөгийн зардлыг сангийн хөрөнгөөр төлсөн нийт 11882.2 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5.төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 60.3.3-д "үндэсний их баяр наадмаас бусад баяр, наадам, ойн арга хэмжээ, шашны зан үйлийн болон ёслолын зардал;" заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "*Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно*" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Дээрх зөрчилтэй холбоотой 9742181 /есөн сая долоон зуун дөчин хоёр мянга нэг зуун наян нэгэн төгрөгийг/-ийг суутган авч Бусад нэр зааж ангилагдаагүй орлогын 100160000955 тоот дансанд төвлөрүүлэх
2. Илүү суутгасан 150000 /нэг зуун тавин мянган төгрөгийг/-ийг ажилтанд буцаан олгох

3. Актын биелэлтийг 2023 оны 06 дугаар сарын 20-ны дотор Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Үенч сумын Засаг дарга Э.Уртнасан, ЗДТГ-ын дарга Ч.Ганбат, Санхүү албаны дарга П.Булганбат, нягтлан бодогч Г.Нандинцэцэг, Н.Ганболд нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Х.БОЛДБААТАР  
АХЛАХ АУДИТОР  Д.НАРАНТУУЛ



ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2023 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 52/A2160424

Ховд

ХОА-2022/13/НА/-СТА-ТТЗ  
ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Үенч сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн тайланд аудитаар ИТХ-ын төлөөлөгч нарт улирлын урамшуулал илүү олгосон, батлагдаагүй зардлыг төсвөөс санхүүжүүлсэн, томилолтоор ажилласан эсэхийг нотлох анхан шатны баримтгүй, томилолтын мөнгө олгосонтой холбоотой нийт 4313.6 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах; "16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх; 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 13.6-д "анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", Засгийн газрын 404 тоот тогтоолоор "ИТХ-ын төлөөлөгчийн үйл ажиллагаа, тэдгээрийг чадавжуулах арга хэмжээний зардлын нийтлэг жишиг, зарцуулах, тайлагнах" журамд заасан заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Дээрх зөрчилтэй холбоотой 4313600 /дөрвөн сая гурван зуун арван гурван мянга зургаан зуун төгрөгийг/-ийг хавсралтад заасны дагуу төлүүлэн Төрийн сангийн бусад нэр зааж ангилагдаагүй орлогын 100160000955 тоот дансанд 2023 оны 06 дугаар сарын 15-ны дотор төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2023 оны 06 дугаар сарын 20-ны дотор Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Үенч сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга Т.Уранбилэг, нягтлан бодогч Н.Ганболд нарт хариуцуулав.
- 3.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН  
ТӨРГҮҮЛЭХ АУДИТОР *Х.Болдбаатар* Х.БОЛДБААТАР  
АХЛАХ АУДИТОР *Д.Нарантуул* Д.НАРАНТУУЛ

<sup>1</sup> Монгол Улс, Ховд аймаг, Жаргалант сум, Цамбагарав баг, Засаг даргын Тамгын газрын байр, 3 давхар Утас: 70433061





ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 30/A2160424

Ховд

ХОА-2022/13/НА-СТА-ТТЗ  
ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Үенч сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар ажлаас халагдсан ажилтанд төсвөөс цалин олгоод буруутай этгээдээс нэхэмжилж аваагүй, авлагад тусгаагүй 9.7 сая төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20.2.5-д дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянаж ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах", Захиргааны ерөнхий хуулийн 103.1-д Иргэн хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага иргэний хуулийн 498.5-д заасны дагуу нэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ", гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2022 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шүүхийн шийдвэрээр олгогдсон хөрөнгийг буруутай этгээдээр нь гаргуулан авах асуудлыг шийдвэрлэн ажиллах
2. Албан шаардлагын биелэлтийг 2023 оны 6 дугаар сарын 15-ны дотор Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Үенч сумын Засаг дарга Э.Уртнасан, ЗДТГ-ын дарга Ч.Ганбат, Санхүү албаны дарга П.Булганбат, нягтлан бодогч Г.Нандинцэцэг, Н.Ганболд нарт хариуцуулав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ДАРГА, ТӨРГҮҮЛЭХ АУДИТОР  Х.БОЛДБААТАР

АХЛАХ АУДИТОР  Д.НАРАНТУУЛ

<sup>1</sup> Монгол улс, Ховд аймаг, Цамбагарав баг, ЗДТГ-ын 3 давхар, Утас:70433061, 70432545

<sup>1</sup> Монгол Улс, Ховд аймаг, Жаргалант сум, Цамбагарав баг, Засаг даргын Тамгын газрын байр, 3 давхар Утас: 70433061